

ГАРЧИГ

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

154.	Дээд офицерын цол хүртээх тухай	Дугаар 34	605
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
155.	“Амгалан дулааны станц” барих тухай	Дугаар 55	606
156.	Стандарчиллын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 64	607
157.	Босго үнэ шинэчлэн батлах тухай	Дугаар 68	608
158.	Бүтээн байгуулалтын томоохон төсөл хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 71	610
159.	Үндэсний агаарын тээвэрлэгч статус олгох тухай	Дугаар 72	611

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 03 дугаар  
сарын 18-ны өдөр Дугаар 34 Улаанбаатар хот

## Дээд офицерын цол хүртээх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 41 дүгээр зарлигаар батлагдсан “Цэргийн

цол олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Загдсүрэнгийн Болдбаатарт “хошууч генерал”, Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа Баянмөнхийн Билэгт, Монгол Улсын Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хилийн цэргийн командлагч, хурандаа Шархүүгийн Лхачинжав нарт “бригадын генерал” цол тус тус хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

ЦАХИАГИЙН  
ЭЛБЭГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 2 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

“Амгалан дулааны станц”  
барих тухай

Эрчим хүчний тухай хуулийн 5.1.1, Хөгжлийн банкны тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл болон 22.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын дулаан хангамжийн хэвийн, найдвартай ажиллагааг 2013-2014 оны өвлийн их ачааллаас өмнө хангах зорилгоор “Амгалан дулааны станц”-ыг “түлхүүр гардуулах” нөхцөлтэйгээр дулааны шугам, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын хамт барих гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулан 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор эхний ээлжийг ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд М.Сономпил, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нарт даалгасугай.

2. “Амгалан дулааны станц”-ын гүйцэтгэлийг дулааны станцыг ашиглалтад хүлээлгэн өгсний дараа зохих журмын дагуу Хөгжлийн банк болон төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлж, төлбөрийг барагдуулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд



Ч.Улаан, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Ус-15” дулааны станц барих тухай” Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 35 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

**М.СОНОМПИЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2013 оны 3 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

### **Стандартчиллын талаар авах зарим арга хэмжээний тухай**

Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 18, 26 дугаар зүйл, Үндэсний стандартын түвшинд явуулсан улсын үзлэгийн дүнг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний стандартыг 2013-2014 онд нэн тэргүүнд шинээр болон шинэчлэн боловсруулах ажлын төлөвлөгөөг 2013 оны 4 дүгээр сард багтаан Стандартчиллын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэхэд нь шаардагдах хөрөнгийг төсвийн багцаасаа болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга наарт даалгасугай.

2. Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын төлөвлөгөөнд стандартчилал, техникийн зохицуулалтын талаар мэдлэг олгох хичээлийг 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн оруулах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт даалгасугай.

3. Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой стандарт,

техникийн зохицуулалтыг хууль тогтоомж, олон улсын жишигт нийцүүлэн боловсруулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг 2014 оноос эхлэн жил бүр улсын төсвээс, стандартчилал, тохирлын үнэлгээний чиглэлээр хийх шинжлэх ухаан технологийн судалгаа, шинжилгээний зардлыг шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, Сангийн сайд Ч.Улаан, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантэмэр нарт тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД

Д.ТЭРБИШДАГВА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар  
хот

### Босго үнэ шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоолоор батлагдсан босго үнийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөн ажиллахыг бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагч, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Босго үнэ батлах тухай” Засгийн газрын 2006 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 22 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын



2007 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 42 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**САНГИЙН САЙД**

**Ч.УЛААН**

Засгийн газрын 2013 оны 68 дугаар  
тогтоолын хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НҮТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР  
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД  
МӨРДӨХ ЖУРМЫГ СОНГОХОД БАРИМТЛАХ БОСГО ҮНЭ

(сая.төг)

№	Босго үнийн өөрчлөлт	Ангилал	Бараа	Ажил	Үйлчилгээ	
					Зөвлөх	Бусад
1	Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар		50.0	80.0	-	50.0
2	Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар		10.0	10.0	-	-
3	Зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох төсөвт өртгийн дээд хязгаар		-	-	50.0	-



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар  
хот

### Бүтээн байгуулалтын томоохон төсөл хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдан томоохон бүтээн байгуулалтын зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бодлогын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөр “Шинэ төмөр зам” төсөл, Дорнод, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Хөвсгөл аймгийн төвийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбох төсөл, “Гудамж” (Улаанбаатар хотын 33 уулзварыг дөрвөн замын уулзвар болгон шинэчлэх болон Туул гол, Сэлбэ голын даланг дагуулан хурдны зам барих) төсөл, Тавантолгойн нүүрсний орд газарт 300МВт цахилгаан станц барих төслийг санхүүжүүлэхээр тогтсугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан бүтээн байгуулалтын томоохон төсөл нэг бүрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий төслийн нэгжийг байгуулан ажиллуулахаар тогтоосугай.

3. Төслийн нэгж байгуулж, бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх талаар дараахь арга хэмжээ авч ажиллан тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, тухайн төсөл хэрэгжиж байгаа салбарын эрхэлсэн сайд, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай:

3.1. бүтээн байгуулалтын төсөл, объектын ажлын зураг төсөл, техник-эдийн засгийн үндэслэлийг захиалж боловсруулах;

3.2. төслийн санхүүгийн болон эдийн засгийн тооцоог хийлгэх;

3.3. төслийн байгаль орчинд нөлөөлөх үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргуулах;



3.4. бүтээн байгуулалтын ажлын нарийвчилсан график, төлөвлөгөө гаргаж, бүтээн байгуулалтын ажлыг гардан зохион байгуулан түүний гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, улмаар ажлыг нь эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

3.5. Төслийн нэгжийн үйл ажиллагааг удирдаж, ажлын хэрэгжилтэд нь хяналт тавьж, төсөл бурийн явцын талаар Засгийн газарт тухай бүр мэдээлж байх.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ЭДИЙН ЗАСГИЙН  
ХӨГЖЛИЙН САЙД

Н.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Ч.САЙХАНБИЛЭГ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 3 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар  
хот

Үндэсний агаарын тээвэрлэгч  
статус олгох тухай

Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын 3.6, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 117.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “МИАТ” ТӨХК-д Үндэсний агаарын тээвэрлэгч статус олгосугай.
2. Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн удирдлага, менежментийг сайжруулах бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах талаар холбогдох

арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Төрийн өмчийн хороо (Д.Цогтбаатар)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.АЛТАНХУЯГ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

А.ГАНСҮХ

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeelel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн худас: 0.5

**Индекс:** 14003